



ОРХОН АЙМГИЙН СОНГУУЛИЙН  
ХОРООНД

ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826

Цахим шуудан: [orkhon@audit.gov.mn](mailto:orkhon@audit.gov.mn)

2024-07-31 № 281  
танай -ны № -т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Иргэдийн Оролцооны Нэгдэл намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 – 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 – 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай

хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Иргэдийн Оролцооны Нэгдэл намын Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцооор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Мөрийн хөтөлбөр .....<sup>З</sup> хуудсыг хавсаргав.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРМАНДАХ



**ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМЫН  
АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Орхон аймаг

Хүний эрх, хувийн хэвшил, тогтвортой хөгжил, иргэний оролцоог эрхэм болгодог баруун төвийн намын хувьд Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН) “боловсрол, бизнесийн орчин, тогтвортой хөгжил” гэсэн гурван голлох чиглэлээр улс орныхоо хөгжилд дэвшилтэт өөрчлөлтийг авчрах зорилт тавин мөрийн хөтөлбөрөө дэвшүүлж байна. Үүнд:

**Нэг: Боловсролын чиглэлээр**

Боловсрол бол Монгол улсын өнөөдөр болон ирээдүйн гол хөрөнгө оруулалт юм хэмээн ИОНН үзэж буй тул “Тэгш хүртээмжтэй сургууль” хөтөлбөрийг онцгой анхаарч ажиллана. Энэхүү хөтөлбөр нь бага дунд болон насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, эцэг, эх, асан хамгаалагч нарын хөдөлмөр, бизнес эрхлэх боломжийг хангах, хүн амын суурь эрүүл мэндийн асуудлыг багасгах, хот байгуулалт, нийтийн тээврийн тулгамдсан асуудлыг эзргээр шийдвэрлэх, хүүхдийг эрүүл аюулгүй орчинд өсгөж боловсролтой иргэн болгоход гүн гүнзгий нөлөө үзүүлэх болно. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд:

- 1.1. Сургуулиудын анги танхимын дүүргэлтийг нэгэн жигд байхаар зохион байгуулалтын өөрчлөлт хийнэ.
- 1.2. Мөрийн хөтөлбөрийн 1.1-д заасан ажлыг хийхэд хамгийн түрүүнд тухайн багийн хүүхэд байнга оршин суудаг хаягийн бүртгэгдэх журмыг батлуулах ажлыг хуулинд нийцүүлэн журамлах ажлыг зохион байгуулна.
- 1.3. Хүүхдийн сурхадаа сургууль, анги танхим, багш, гэр бүл, сургуулийн эргэн тойрны зай талбай, орчны хөршүүд багтах тул сургуулийн үйл ажиллагааны дүрэм, сургалтын хөтөлбөр зэргийг дээрээс батлахыг халж, харин сургууль дундын сургалтын мэргэжилтэн, тухайн сургуулийн багш, эцэг эх, асан хамгаалагч нар хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

**Хоёр. Бизнесийн орчны чиглэлээр: Шударга татвар- Тэгш орчин**

Хувийн хэвшил бол улс орны эдийн засгийн гол хөдөлгөгч хүч гэж Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам үздэг учраас хувийн хэвшилд бизнесийн тэгш боломж, эрүүл өрсөлдөөний орчныг хангах нь бидний гол зорилтын нэг юм. Өнөөгийн бизнесийн орчин нь улс төр маш их холилдсон, цөөн хэдэн компани шударга бус давуу байдлаа ашиглан бусдынхаа бизнесийн орон зайлж хумьсан, бизнес эрүүлмээр өсөж өндийх, тэлэх нөхцөл алдагдсанаас үүдэн залуучууд эх орондоо бизнес хийхээс шантарч олноороо гадаад улс руу гарах болсон нь манай орны хөгжлийг хойш татах хэмжээнд хүрлээ гэж ИОНН үзэж байна. Иймээс татвар, төсөв, өрсөлдөөний бодлогыг доорх байдлаар өөрчилж бизнесийн бичигийг сайжруулна. Үүнд:

- 2.1. Орон нутгаас өгдөг аливаа тусгай зөвшөөрөл, хяналт шалтгалтыг цөөлөх болон шаардлагатай гэж үзвэл зайлшгүй олгох ажлыг хангасчлэх ажлыг зохион байгуулна.
- 2.2. Тухайн аймаг сумын иргэн төрийн худалдан авалтанд оролцох мэдээллийн ил тод байдлыг бий болгож, хэрэв хуулиар заасан шаардлагыг хангасан бол



тухайн сум, аймгийн бизнес эрхлэгч давуу эрхтэй оролцох ажлын талаар хууль тогтоомжинд оруулах өөрчлөлтийг санал болгож, журам боловсруулна.

## Гурав. Тогтвортой хөгжлийн чиглэлээр

Байгаль орчин, иргэний боловсрол нь тогтвортой хөгжлийн бат суурь гэж Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам үздэг ба дараах бодлогыг иргэдийн идэвхтэй оролцооны тусламжтайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.1. Хур тунадас багатай, гандуу хуурайгаас үүдэн гамшиг тохиолдох магадлалтай Монгол оронд эзэмшил газар болон бэлчээрийн ногоон бүрхүүлийг нэмэгдүүлэх “Хурын шим” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Усны хүртээмж багатай Монголд орны хувьд иргэд ганцаараа буюу хамтран өөрийн болон дундын эдэлбэр газарт ногоон байгууламж барих түүнийг хувийн хэвшлийн банк санхүүгийн байгууллагаас санхүүжүүлэх үйл ажиллагааг хөхиүүлэн дэмжсэн хууль эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- 3.2. Монгол орны байгаль цаг уур, газар зүйн нөхцөл байдлын онцлогт нийцсэн, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох аливаа үйл ажиллагааг иргэд хувийн хэвшилтэй хамтран шийдэж үр дүн гарч байгаа бол тэдгээр үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн зохион байгуулалтын ухаалаг дэмжлэг үзүүлнэ. Нэг удаагийн далайлтаар компаничлах замаар аливаа тогтвортой шийдлийг устгадаг байдлыг таслан зогсоно.
- 3.3. Орчны бохирдлыг багасгахад иргэдийн оролцоотой, тогтвортой шийдлийг дэмжинэ. Иргэд бүтээх, боловсруулах ўе шатанд нь оролцоогүй, хэрэглээнд нэвтрэсний дараа иргэдийн хариу үнэлгээнд суурилсан хөгжүүлэлт хийгдээгүй, Монгол орны эрс тэс уур амьсгалд 24 сараас доошгүй хугацаанд туршигдаагүй аливаа технологийг улсын төсвөөс санхүүжүүлэхгүй ба түүнд Засгийн газрын баталгаа гаргахгүй. Ногоон хөгжилд зориулсан болон орчны бохирдлын эсрэг бүтээгдэхүүн нь эрс тэс уур амьсгал, хэрэглэгчдийн соёлд нийцэх эсэх нь 24 сарын ашиглалтын явцад нотлогдсон бол худалдан авалт, бусад хөнгөлөлтийн дэмжлэгт хамрагдана.
- 3.4. “Иргэдийн оролцоо - Нийтийн Хяналт”-ын соёлыг бүтээн байгуулалтын талбар болон орон нутгийн удирдлагад тавих иргэний хяналтыг хуульчилж нэвтрүүлнэ. Аливаа бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлыг иргэдийн оролцоогүйгээр шийддэг байдлыг хална.
- 3.5. Аливаа бүтээн байгуулалт болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг эхлэхээс хамгийн багадаа нэг жилийн өмнө үйл ажиллагаанд шууд өртөх иргэдтэй уулзалт, танилцуулга эхлүүлсэн байхыг шаардана. Хэрэв иргэдийн 85% нь дэмжвэл төслийг эхлүүлэх зөвшөөрлийг авах ба нөхөн төлбөрийн асуудлыг эрх ашиг нь хөндөгдөж буй талуудтай заавал тохирч, гэрээгээр баталгаажуулсан байхыг шаардана.
- 3.6. Эрх ашиг нь хөндөгдөж буй талд олгох нөхөн төлбөр болон орчны иргэдийн хөдөлгөөний нягтралд орж буй өөрчлөлтийг хэрхэн зохицуулах зэрэг асуудлыг тусгасан гэрээгүйгээр тухайн төслийн үйл ажиллагааг эхлүүлэх зөвшөөрөл өгсөн байвал иргэдтэй зөвшилцөөгүйн  хор хохирлыг уг ажлыг эхлүүлэхийг зөвшөөрсөн албан тушаалтаар төлүүлдэг болгоно.
- 3.7. Хэрэв Төрийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар аливаа бүтээн байгуулалт хийж буй бол тухайн бүтээн байгуулалтын байршил сонгох асуудлаар заавал нийтийн сонсгол хийдэг болгоно. Төрийн байгууллагын санаачилгаар уг бүтээн байгуулалтыг хийх бол нээлттэй хэлэлцүүлэг, сонсголын зардлыг тухайн төслийн төсөвт тусгадаг тогтолцоо нэвтрүүлнэ.

- 3.8. Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл нь иргэдэд учрах гамшгийн аюулыг нэмэгдүүлж байвал уг төсөлд зөвшөөрөл өгөхийг хориглоно. Улс, орон нутгийн төсөв, олон улсын болон гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж буй аливаа төсөл, бүтээн байгуулалт нь тухайн орон нутгийн гамшгаас хамгаалах байнгын, үндсэн бүтцийг эвдэх, устгах, гамшгаас хамгаалах чадавхыг сулруулах, эсхүл ийм бүтэц байгуулахаар төлөвлөсөн байршлыг эзлэх, хааж хা�ших үр дагавартай байгаа бол уг төсөлд зөвшөөрөл олгохыг хориглоно. Хэрэв үүнийг зөрчиж зөвшөөрөл олгосон бол зөвшөөрөл олгосон бүх шатны албан тушаалтан, нийтийн аюулгүй байдлын өмнөөс төслийг хянаж нягтлах мэргэжлийн үүрэг хүлээсэн этгээдэд эрүүгийн хариуцлага ногдуулдаг тогтолцоо нэвтрүүлнэ.
- 3.9. Иргэний боловсрол, иргэд орчныхоо болон Монгол улсынхаа тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах шийдлийг харилцан зөвшилцэж гаргах үйл ажиллагааг иргэний нийgmээр дамжуулан дэмжинэ.

